



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/Н/96

Дархан

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3 "н" дэх заалт, Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлагыг хэрэгжүүлэх, нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Т.Ганболд	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	С.Баясгалан	Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	С.Ганзориг	Аймгийн ИТХ-ын Байгаль орчны экологийн бодлого хяналтын хорооны гишүүн
	Т.Атархишиг	Хонгор сумын Засаг дарга
	Д.Амарсанаа	Шарын гол сумын Засаг дарга
	Ж.Баярт-Од	Татварын хэлтсийн дарга
	П.Энх-Амгалан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Д.Бат-Эрдэнэ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Л.Бат-Эрдэнэ	Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүлэгч
	О.Лувсаншарав	"Уулс ноён" ХХК-ийн төлөөлөл

2. Дээрх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлагыг хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөл /Т.Ганболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.НАСАНБАТ